



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/30/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|----|
| 1. Аудитын гэрчилгээ | 2 |
| 2. Аудитын тайлан..... | 4 |
| 2.1. Оршил | 4 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 6 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 6 |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 7 |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 7 |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 8 |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл | 8 |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 8 |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 8 |
| 3. Менежментийн захидал | 9 |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 11 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 11 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 12 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 14 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 16 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 17 |
| 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан..... | 19 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

1. Аудитын гэрчилгээ


| | |
|--|--|
|  ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn | ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН ҮҮД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ А.СҮРЭНХҮҮ ТАНАА |
| <p>2020.02.28 № 1-6/224 танай _____ -ны № _____ -т</p> | |
| Аудитын гэрчилгээ | |
| <p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p> | |
| Зөрчилгүй санал дүгнэлт | |
| <p>Дорноговь аймгийн Замын Үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p> | |
| Санал дүгнэлтийн үндэслэл | |
| <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p> | |
| <p>Аудитаар Дорноговь аймгийн Замын Үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p> | |
| <p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p> | |

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн захирал А.Сүрэнхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, элэгдэл дууссан ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, өглөг, авлагын тооцоог барагдуулах, тооцоо нийлж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ний захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Р.Пүрэвсүрэн, туслах аудитор Э.Номинчулуун нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Уваа Уул аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 009 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд

аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд бүрийн оролцоог дэмжин сурагчдын суурь чадварыг хөгжүүлж, оюуны хурдыг ахиулахад”-д оршино.

Бүрэн дунд боловсролын үйл ажиллагааны чиглэлийг “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 6 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх;
- Байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх;
- Бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-06-10-ны 11/09 “Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-12-04-ны 12/07 “Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна..

Дорноговь аймгийн Замын үүд сумын 1 дүгээр сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ний “Acoulous, payroll” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дугаар улирлын Санхүүгийн үр дүнгийн тайланг сонгож, эрсдэлийн түвшин “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 942854.1 мянган төгрөгөөс тооцон 9428.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 17556.9 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийн түвшин “дунд” үзсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65543,3 мянган төгрөгөөр буюу 1,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|--------------------|---------------------|-----------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 17,176.1 | 27,937.3 | 10,761.2 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 128,257.7 | 117,952.5 | -10,305.2 |
| Үндсэн хөрөнгө | 3,846,978.9 | 3,912,066.2 | 65,087.3 |
| Нийт хөрөнгө | 3,992,412.7 | 4,057,956.00 | 65,543.3 |
| Өр төлбөр | 1,202.8 | 217.7 | -985.1 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,991,209.9 | 4,057,738.3 | 66,528.4 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 3,992,412.7 | 4,057,956.00 | 65,543.3 |

Авлага дансны үлдэгдэл өссөн нь Хүүхэд хөгжлийн түлхүүр- Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 2019-2020 оны хооронд 2 он дамжин хэрэгжих хөтөлбөрийн 2020 онд зарцуулагдах төсвийн үлдэгдэл нь орон нутагт төвлөрүүлэн шилжүүлж авлага өсөхөд шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 10,643,7 төгрөгийн авлага 2017 онд үүссэн. Үүнээс 10,577,1 мянган төгрөгийн авлага нь БАТТОД ХХК нь 2017 онд бага сургууль

дотуур байрны камержуулалтын тендерт шалгарч 2018 оны 1-р сард камержуулалтын ажлаа бүрэн хийж барагдуулсан боловч холбогдох бичиг баримтаа хүлээлгэж өгөөгүй байгаа тул авлага нь өнөөг хүртэл хаагдаагүй байгаа. Энэ асуудлыг шийдвэрлэж өгөхийг холбогдох газруудад нь албан тоотоор хүргүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 34,894.9 мянган төгрөгийн бараа материал акталæ, 4,356.0 мянган төгрөгийн бараа материал шилжүүлсэн. Төсвийн хөрөнгөөр 109,468,3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 96,626,3 мянган төгрөг зарцуулсан байна. Төсөвт байгууллагаас хандиваар 16,103,7 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 2019 онд Дорноговь аймгийн ИТХурлын тогтоол мөн Замын-Үүд сумын ИТХТэргүүлэгчдийн тогтоолоор нийт 224,787,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актлагдаж данснаас хаснаа. Замын-Үүд сумын ИТХТэргүүлэгчдийн тогтоолоод 001 нийт 3-р сургуульд 19,278,5 мянган төгрөгийн, Соёл спортын ордонд 2,087,2 мянган төгрөгийн нийт 21,365,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж данс бүртгэлээс хассан байна. Төсвийн хөрөнгөөр 68,049,8 үндсэн хөрөнгө бэлтгэгдсэн байна. Мөн хандиваар 38,663,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь 2018 онд 0лш халаалт, цэвэр бохир усны зардал дээр 906,0 мянган төгрөгийн, 2017 оноос Ариутгал халдваргүйтэл дээр 296,7 мянган төгрөгийн өртэй байсан үү бүрэн төлөгдөж 2019 онд шинээр ХЧТА тэтгэмжийн хувь хүнд 217.7 мянган төгрөгийн өр шинээр бүртгэгдсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 1 хөтөлбөрт зориулан 1,731,387.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,731,387.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,467,074.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 264,313.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлыг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,724,883.1 мянган төгрөг буюу 99,6 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлаас 20,327.7 мянган төгрөг хэмнэгдэж, эд хогшил урсгал засварын зардлаас 225,0 мянган төгрөгийн хэмнэлт тус тус гарснаас шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: 2019-2020 оны хооронд 2 он дамжин хэрэгжих Хүүхэд хөгжлийн түлхүүр-Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрөөс 26,000,0 мянган төгрөгийн санхүүжилт орсон байна.

Үүнээс 8,391,0 мянган төгрөгийг Багаж техник хэрэгсэл-д, 1,367,4 мянган төгрөгийг Тавилга-д зарцуулж, үлдэгдэл 16,241,600 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 63,641.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 10,941.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 52,700.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч байна.

Аудитаар илэрсэн 52,700.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж хэрэгжилт, түүний зардлыг хянахад анхаарал хандуулах чухал гэж үзсэн.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын үүд сумын 1 дугаар сургууль нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 131 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,284.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосноос 5,867.3 мянган төгрөгийн актыг барагдуулсан, 417,0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээс 417,0 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бид Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 155,661.7 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн бодитой илэрхийлэгдэхгүй байх, хөрөнгийн ашиглалт алдагдах.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хөрөнгийн ашиглагдах жил, үнийг шинэчлэн тогтоох.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч нар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3.2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нийт харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан

авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэн заалттай нийцэхгүй, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Өглөг авлагын үлдэгдлээр тусгаагүй ажил гүйлгээнүүдэд дотоод хяналт сулаас залилангийн эрсдэл үүсэх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн тооцоог хийж, үлдэгдлийг баталгаажуулан, баталгаажсан дүнг санхүүгийн тайланд тусгаж байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дорноговь аймгийн Замын Үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч нар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өөрийн аудитын газарт 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 145,433,806.57 | 145,889,812.09 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 0.00 | 0.00 |
| 33 | АВЛАГА | 17,176,063.39 | 27,937,297.15 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 538,222.00 | 690,190.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 0.00 | 0.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 246,900.00 | 0.00 |
| 33500 | Бусад авлага | 16,390,941.39 | 27,247,107.15 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 16,389,141.39 | 27,246,511.15 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,800.00 | 596.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 128,257,743.18 | 117,952,514.94 |
| 35100 | Түүхий эд материал | 27,690,257.94 | 23,921,207.94 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 27,690,257.94 | 23,921,207.94 |
| 35400 | Хангамжийн материал | 100,567,485.24 | 94,031,307.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 227,342.00 | 227,342.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 52,884,863.21 | 48,481,965.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 40,000.00 | 0.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,118,730.00 | 96,150.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 43,296,550.03 | 45,225,850.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,846,978,885.80 | 3,912,066,174.85 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,846,978,885.80 | 3,912,066,174.85 |
| 39200 | Биет хөрөнгө | 3,632,088,885.80 | 3,697,176,174.85 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,117,745,676.89 | 5,117,745,676.89 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,817,668,121.68) | (1,825,943,490.85) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 408,666,721.27 | 310,505,157.22 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (244,495,049.72) | (111,572,427.91) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 267,674,196.82 | 221,467,207.43 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (126,112,467.42) | (2,885,943.94) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 76,263,755.42 | 54,238,481.09 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (60,767,806.78) | (44,113,652.08) |
| 39217 | Ном | 10,781,981.00 | 37,735,167.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 214,890,000.00 | 214,890,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,727,798.00 | 2,727,798.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,727,798.00) | (2,727,798.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 214,890,000.00 | 214,890,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,992,412,692.37 | 4,057,955,986.94 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,202,756.00 | 217,737.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,202,756.00 | 217,737.00 |
| 41300 | Өглөг | 1,202,756.00 | 217,737.00 |
| 41360 | Бусад өглөг | 1,202,756.00 | 217,737.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,202,756.00 | 0.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 0.00 | 217,737.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,991,209,936.37 | 4,057,738,249.94 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,991,209,936.37 | 4,057,738,249.94 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,577,698,149.51 | 1,577,698,149.51 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | -327,194,909.96 | -260,666,596.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -251,002,917.25 | -327,194,909.96 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (76,191,992.71) | 66,528,313.57 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,740,706,696.82 | 2,740,706,696.82 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,992,412,692.37 | 4,057,955,986.94 |

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,673,823,792.32 | 1,822,218,132.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 110,715,992.32 | 54,766,740.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 110,715,992.32 | 54,766,740.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 110,715,992.32 | 54,766,740.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,949,100.00 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 100,766,892.32 | 54,766,740.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,563,107,800.00 | 1,767,451,392.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,563,107,800.00 | 1,467,074,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,563,107,800.00 | 1,467,074,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 36,063,592.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 26,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 10,063,592.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 0.00 | 264,313,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 0.00 | 264,313,800.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,618,287,451.99 | 1,742,514,331.35 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,618,287,451.99 | 1,742,514,331.35 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,524,398,137.29 | 1,662,267,245.80 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 899,611,796.81 | 1,147,775,851.16 |
| 210101 | Үндсэн цалин | 544,921,326.51 | 807,714,518.97 |
| 210102 | Нэмэгдэл | 259,226,076.10 | 272,086,989.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 81,354,072.00 | 67,974,342.23 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 14,110,322.20 | 0.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 106,302,844.41 | 146,059,522.53 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,365,560.81 | 105,199,734.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,375,032.93 | 8,256,418.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,129,100.00 | 10,352,536.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,594,600.00 | 719,646.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,838,550.67 | 21,531,185.79 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 270,986,886.00 | 255,732,584.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 226,352,786.00 | 210,098,484.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 24,634,100.00 | 25,634,100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 85,885,776.00 | 44,343,462.24 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,603,270.00 | 1,292,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 360,000.00 | 1,340,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 721,437.00 | 678,990.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 363,000.00 | 71,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,328,900.00 | 1,460,500.00 |

| | | | |
|-------------|---|-----------------------|----------------------|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 79,259,169.00 | 39,250,872.24 |
| 2105 | Нормативт зардал | 14,082,634.00 | 16,601,884.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 279,500.00 | 180,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,900,334.00 | 14,621,884.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,902,800.00 | 1,800,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 26,031,800.00 | 7,713,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 3,876,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,031,800.00 | 3,837,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,099,156.00 | 3,188,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,099,156.00 | 3,188,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,086,905.00 | 6,298,122.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,076,905.00 | 5,578,122.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 720,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 10,000.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 119,310,339.07 | 34,553,419.87 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,653,000.00 | 453,260.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,629,099.00 | 5,650,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 105,028,240.07 | 28,450,159.87 |
| 212 | ТАТААС | 4,644,900.00 | 663,900.00 |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 0.00 | 663,900.00 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 0.00 | 663,900.00 |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 4,644,900.00 | 0.00 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 4,644,900.00 | 0.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 89,244,414.70 | 79,583,185.55 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 83,425,800.00 | 73,078,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 56,491,800.00 | 67,273,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 26,934,000.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 5,805,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.00 | 6,504,685.55 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 6,504,685.55 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5,818,614.70 | 0.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,818,614.70 | 0.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 55,536,340.33 | 79,703,800.65 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 131,728,333.04 | 13,175,487.08 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 131,728,333.04 | 13,175,487.08 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -76,191,992.71 | 66,528,313.57 |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,574,056,908.00 | 1,767,451,392.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,000,008.00 | 0.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,000,008.00 | 0.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,000,008.00 | 0.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,008.00 | 0.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,573,056,900.00 | 1,767,451,392.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,563,107,800.00 | 1,467,074,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,563,107,800.00 | 1,467,074,000.00 |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | 0.00 | 0.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 9,949,100.00 | 36,063,592.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,949,100.00 | 26,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 10,063,592.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 0.00 | 264,313,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 0.00 | 264,313,800.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,573,657,008.00 | 1,699,401,542.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,573,657,008.00 | 1,699,401,542.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,475,360,893.30 | 1,607,376,186.45 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 891,207,702.30 | 1,146,934,208.91 |
| 210101 | Үндсэн цалин | 529,958,014.00 | 807,715,902.11 |
| 210102 | Нэмэгдэл | 265,785,294.10 | 272,086,989.96 |
| 210104 | Урамшуулал | 81,354,072.00 | 67,131,316.84 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 14,110,322.20 | 0.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 105,612,600.00 | 145,667,595.54 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,729,800.00 | 105,025,599.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,375,200.00 | 8,269,643.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,129,100.00 | 10,388,599.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,594,600.00 | 1,207,053.04 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,783,900.00 | 20,776,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 250,000,000.00 | 256,638,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 205,365,900.00 | 211,004,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 24,634,100.00 | 25,634,100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,589,695.00 | 6,024,690.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 800,000.00 | 1,114,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 400,000.00 | 1,300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 761,895.00 | 785,690.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,877,800.00 | 2,075,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 17,602,578.00 | 12,578,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 279,500.00 | 180,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,938,178.00 | 10,598,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,384,900.00 | 1,800,000.00 |

| | | | |
|-------------|---|-----------------------|----------------------|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 178,988,865.00 | 23,596,070.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,500,000.00 | 19,361,000.00 |
| 210602 | Тавилга | 0.00 | 397,470.00 |
| 210604 | Урсгал засвар | 167,488,865.00 | 3,837,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,099,148.00 | 3,188,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,099,148.00 | 3,188,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,499,905.00 | 6,298,122.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,499,905.00 | 6,298,122.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,760,400.00 | 6,450,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,400,000.00 | 750,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,360,400.00 | 5,700,000.00 |
| 212 | ТАТААС | 4,644,900.00 | 0.00 |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 4,644,900.00 | 0.00 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 4,644,900.00 | 0.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 93,651,214.70 | 92,025,355.55 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 87,585,700.00 | 68,918,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 60,651,700.00 | 63,113,600.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 26,934,000.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 5,805,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 246,900.00 | 6,504,685.55 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 6,504,685.55 |
| 213304 | Хөрөнгийн | 0.00 | 0.00 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 246,900.00 | 0.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 0.00 | 16,602,070.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 16,602,070.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5,818,614.70 | 0.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,818,614.70 | 0.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 399,900.00 | 68,049,850.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 399,900.00 | 68,049,850.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 399,900.00 | 68,049,850.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 399,900.00 | 68,049,850.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 399,900.00 | 68,049,850.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | 399,900.00 | 68,049,850.00 |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----------|---|---------------------------------|-------------------------|------------------------|--|
| 1 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,362,808,149.51 | 538,372,286.69 | -250,892,107.25 | 1,650,288,328.95 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | (110,810.00) | (110,810.00) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,362,808,149.51 | 538,372,286.69 | -251,002,917.25 | 1,650,177,518.95 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 2,202,334,410.13 | 0.00 | 2,202,334,410.13 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 214,890,000.00 | 0.00 | 0.00 | 214,890,000.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (76,191,992.71) | (6,191,992.71) |
| 10 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,577,698,149.51 | 2,740,706,696.82 | (327,194,909.96) | 3,991,209,936.37 |
| 11 | 2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,577,698,149.51 | 2,740,706,696.82 | -327,194,909.96 | 3,991,209,936.37 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,577,698,149.51 | 2,740,706,696.82 | -327,194,909.96 | 3,991,209,936.37 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 66,528,313.57 | 66,528,313.57 |
| 20 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,577,698,149.51 | 2,740,706,696.82 | -260,666,596.39 | 4,057,738,249.94 |

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------|---|-------------------------|-------------------------|-----------------|-------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,731,387,800.00 | 1,724,883,114.45 | (6,504,685.55) | 99.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,731,387,800.00 | 1,724,883,114.45 | (6,504,685.55) | 99.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,667,473,800.00 | 1,660,969,514.45 | (6,504,285.55) | 99.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,167,261,900.00 | 1,146,934,208.91 | (20,327,691.09) | 98.3 |
| 210101 | Үндсэн цалин | 806,781,900.00 | 807,715,902.11 | 934,002.11 | 100.1 |
| 210102 | Нэмэгдэл | 292,272,900.00 | 272,086,989.96 | (20,185,910.04) | 93.1 |
| 210104 | Урамшуулал | 68,207,100.00 | 67,131,316.84 | (1,075,783.16) | 98.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 131,157,600.00 | 145,667,595.54 | 14,509,995.54 | 111.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,138,700.00 | 105,025,599.31 | 16,886,899.31 | 119.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,603,700.00 | 8,269,643.77 | (334,056.23) | 96.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,754,700.00 | 10,388,599.42 | (366,100.58) | 96.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,151,100.00 | 1,207,053.04 | (944,046.96) | 56.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,509,400.00 | 20,776,700.00 | (732,700.00) | 96.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 256,638,600.00 | 256,638,600.00 | 0.00 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,000,000.00 | 20,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 211,004,500.00 | 211,004,500.00 | 0.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 25,634,100.00 | 25,634,100.00 | 0.00 | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,250,000.00 | 8,249,610.00 | (390.00) | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 800,000.00 | 1,114,000.00 | 314,000.00 | 139.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,300,000.00 | 1,300,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,100,000.00 | 785,690.00 | (314,310.00) | 71.4 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 | 250,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,300,000.00 | 4,299,920.00 | (80.00) | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 12,578,100.00 | 12,578,100.00 | 0.00 | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 180,000.00 | 180,000.00 | 0.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 10,598,100.00 | 10,598,100.00 | 0.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,800,000.00 | 1,800,000.00 | 0.00 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 50,337,600.00 | 50,112,600.00 | (225,000.00) | 99.6 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 28,600,000.00 | 28,375,000.00 | (225,000.00) | 99.2 |
| 210602 | Тавилга | 17,900,000.00 | 17,900,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 3,837,600.00 | 3,837,600.00 | 0.00 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,200,000.00 | 3,188,800.00 | (11,200.00) | 99.7 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,200,000.00 | 3,188,800.00 | (11,200.00) | 99.7 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,600,000.00 | 1,600,000.00 | 0.00 | 100.0 |

| | | | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|----------------|-------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,600,000.00 | 1,600,000.00 | 0.00 | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,450,000.00 | 36,000,000.00 | (450,000.00) | 98.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 750,000.00 | 750,000.00 | 0.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 35,700,000.00 | 35,250,000.00 | (450,000.00) | 98.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 63,914,000.00 | 63,913,600.00 | (400.00) | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 63,914,000.00 | 63,913,600.00 | (400.00) | 100.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 63,114,000.00 | 63,113,600.00 | (400.00) | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 800,000.00 | 0.00 | 100.0 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,731,387,800.00 | 1,731,387,800.00 | 0.00 | 100.0 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,470,911,600.00 | 1,467,074,000.00 | (3,837,600.00) | 99.7 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,470,911,600.00 | 1,467,074,000.00 | (3,837,600.00) | 99.7 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 260,476,200.00 | 264,313,800.00 | 3,837,600.00 | 101.5 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 260,476,200.00 | 264,313,800.00 | 3,837,600.00 | 101.5 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 1,416.00 | 1.00 | (1,415.00) | 0.1 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | 0.00 | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 0.00 | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 91.00 | 0.00 | (91.00) | 0.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 0.00 | (1.00) | 0.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 57.00 | 0.00 | (57.00) | 0.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 30.00 | 0.00 | (30.00) | 0.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 3.00 | 0.00 | (3.00) | 0.0 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 1,233.00 | 0.00 | (1,233.00) | 0.0 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 1,233.00 | 0.00 | (1,233.00) | 0.0 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1,233.00 | 0.00 | (1,233.00) | 0.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 91.00 | 0.00 | (91.00) | 0.0 |
| 650004 | СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 91.00 | 0.00 | (91.00) | 0.0 |

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|--|------------|----------------------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 36,063,592.00 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | | 36,063,592.00 |
| Бараа, үйлчилгээний зардал | | 14,456,522.00 |
| Эд хогшил худалдан авах | | 9,758,400.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | | 8,391,000.00 |
| Урсгал засвар | | 1,367,400.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | | 4,698,122.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 4,698,122.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 5,005,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | | 5,005,000.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | | 16,602,070.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 36,063,592.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | | 36,063,592.00 |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 26,000,000.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 10,063,592.00 |

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | |
|------------------------------|---|-------------------------------------|
| Огноо: 2020.02.25 | Аудитын нэр: <i>Дорноговь аймгийн Замын үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i> | Аудитын код: ДГА-2020/30/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | <i>Дорноговь аймгийн Замын үүд сумын 1 дугаар сургууль</i> | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|------------|---------------------------------------|---|---------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байна | 155,661.7 | Зөвлөмж | Нягтлан бодогч | Ц.Эрдэнэчимэг |
| 2 | Харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн тооцоо хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна | 52,700.0 | Зөвлөмж | Нягтлан бодогч | Ц.Эрдэнэчимэг |